СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: “АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ”

Аудитын код: ДА-2026/12/ҮА

Сүхбаатар хот, 2026 он

АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ . 5
1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 7
1.1 ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн үндсэн хөрөнгийн мэдээллийн 2024, 2025 оны харьцуулалт 8
2. АУДИТЫН ҮР ДҮН 11
2.1 Аудитын дүгнэлт 11
2.2 Илэрсэн зөрчлийн нэгтгэл 12
3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ 13
3.1 Зорилт 1. Үндсэн хөрөнгийн нэгтгэсэн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдал хангагдаагүй байна 13
3.2 Зорилт 2. Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх, ангилах, үнэлэх ажил стандарт, журмын дагуу хийгдээгүй байна 18
3.3 Зорилт 3. Элэгдэл тооцох, ашиглалтын хугацаа тогтоох, данснаас хасах үйл явцад хяналт хангалтгүй байна 25
4. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ЗӨВЛӨМЖ 27
4.1 Зөрчлийг шийдвэрлэх гарц, байгууллага хоорондын уялдаа 27
4.1.1 Хяналтын болон мэдээлэл эзэмшигч байгууллагуудын уялдаа 28
4.1.2 Зөрчлийг залруулах нэгдсэн арга 29
4.2 Мал, биологийн хөрөнгийн бүртгэл 30
4.3 Зөвлөмж (хариуцах эзнээр) 31
5. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, УДИРДЛАГЫН ХАРИУ 33
ХАВСРАЛТ 1. БАЙГУУЛЛАГА ТУС БҮРЭЭР ЗӨРЧЛИЙН ТӨРЛӨӨР НЭГТГЭСЭН ДҮН 36
ХАВСРАЛТ 2. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЛДЭХ ӨРТГИЙН ЗӨРҮҮ БАЙГУУЛЛАГААР /сая төгрөг/ 40
ХАВСРАЛТ 3. ДҮ (39216) ДАНСАНД БҮРТГЭЛТЭЙ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ 43
ХАВСРАЛТ 4. ЭЗЭМШЛИЙН ГАЗРЫН БҮРТГЭЛИЙН ЗӨРҮҮ БАЙГУУЛЛАГААР 44
ХАВСРАЛТ 5. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ЗӨРҮҮ БАЙГУУЛЛАГААР 46

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (ОНӨААТҮГ орно)
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДҮ	Дуусаагүй барилга, байгууламжийн данс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
РД	Регистрийн дугаар
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар
СХШУАБ	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮХ	Үндсэн хөрөнгө
ХУР	Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

д/д	Тайлбар	Хуудасны дугаар
1	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, 2024–2025 он	7
2	ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн үндсэн хөрөнгийн дүн, 2024–2025 оны харьцуулалт	8
3	ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн мэдээллийн зөрүү, 2024–2025 он	9
4	Илэрсэн зөрчлийн нэгтгэл	12
5	Хяналтын болон мэдээлэл эзэмшигч байгууллагуудын уялдаа	28
6	Зөрчил тус бүрийн залруулгын нэгдсэн арга	29
7	Удирдлагын арга хэмжээний төлөвлөгөө	33

ГРАФИКИЙН ТОВЬЁГ

д/д	Тайлбар	Хуудасны дугаар
1	Үндсэн хөрөнгийн бүтэц (ОНӨГ-ын бүртгэлээр, 2025)	8
2	ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн үндсэн хөрөнгийн дүн, 2024–2025 он	9
3	Үлдэх өртгийн зөрүү, 2024–2025 он	10
4	Илэрсэн зөрчил төрлөөр	13

ХАВСРАЛТ

д/д	Хавсралтын нэр	Хуудасны дугаар
1	Байгууллага тус бүрээр зөрчлийн төрлөөр нэгтгэсэн дүн	36
2	Үндсэн хөрөнгийн үлдэх өртгийн зөрүү байгууллагаар	39
3	ДҮ (39216) дансанд бүртгэлтэй хөрөнгийн жагсаалт	42
4	Эзэмшлийн газрын бүртгэлийн зөрүү байгууллагаар	43
5	Тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү байгууллагаар	45

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төсвийн тухай хуулийн 14.2.10, 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 14 дүгээр зүйлийн 14.2, 78 дугаар зүйлийн 78.2.4, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.10, 5.1.1 дэх заалт, Сэлэнгэ аймгийн Дотоод аудитын хорооны 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлсан төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр батлсан ДА-2026/12/YA кодтой удирдамжийн дагуу нийцлийн аудитын хэлбэрээр гүйцэтгэв. Ажлын баримтыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/06 дугаар тушаалаар батлсан маягтын дагуу бүрдүүлэв.
Аудитын зорилт:	Аудитын зорилго нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, төсвийн хөрөнгийн удирдлага, зарцуулалт ил тод, нээлттэй байгаа эсэхийг баталгаажуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмжийг хариуцах эзэн, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино. Удирдамжийн шалгах чиглэлийн хүрээнд дараах зорилтыг тавив. Үүнд: • *ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан, ОНӨГ-ын нэгдсэн бүртгэл, ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн мэдээлэл хоорондоо уялдсан, үнэн зөв эсэх;* • *Үндсэн хөрөнгийг стандарт, журмын дагуу хүлээн зөвшөөрч, зөв ангилж, үнэлж бүртгэсэн эсэх;* • *Элэгдэл тооцох, ашиглалтын хугацаа тогтоох, данснаас хасах үйл ажиллагаанд хяналт хангалттай эсэх.*
Аудитын хамарсан хүрээ:	Удирдамжаар ТЕЗ-ийн харьяа нийт 128 байгууллагыг хамруулахаар төлөвлөснөөс 87 байгууллагын (ТШЗ-64, ААТҮГ-23) 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, ОНӨГ-ын хөрөнгийн нэгдсэн бүртгэл, Газрын нэгдсэн бүртгэлийн систем, АТҮТ болон татварын албаны тээврийн хэрэгслийн мэдээллийг хамруулав

Аудитын арга зүй:	Аудитыг Дотоод аудитын дэлхийн стандарт (Global Internal Audit Standards, 2024), төрийн дотоод аудитын холбогдох журмын дагуу гүйцэтгэж, ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн мэдээллийг байгууллага тус бүрээр тулгах, хөрөнгө тус бүрээр дүн шинжилгээ хийх, гадаад эх сурвалжийн (Газрын нэгдсэн систем, АТҮТ, татвар) мэдээлэлтэй харьцуулах аргыг ашиглав. **Хамрах хүрээний хязгаарлалт:** Байгууллагуудын хөрөнгийн бүртгэл өөр өөр программ хангамжид, нэр, кодчиллын нэгдсэн стандартгүй хөтлөгддөг тул ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн мэдээллийг байгууллагын нэр, РД-ээр холбож тулгахад цаг хугацаа их зарцуулагдсан. 2024 оны санхүүгийн тайлангаа 16 байгууллага (ТШЗ-14, ААТҮГ-2) ирүүлээгүй тул тэдгээрийг ТЕЗ–ТШЗ-ийн харьцуулалтад хамруулаагүй болно. Удирдамжийн 3.1-д заасан шалгах чиглэлээс хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай ашиглаж буй эсэх, илүүдэл, ашиглагдахгүй хөрөнгийн судалгаа, түрээсийн гэрээ, түүний орлого, хөрөнгийн хадгалах орчин нөхцөл, эд хөрөнгийн хариуцлагын гэрээ, даатгалд хамрагдалт, урсгал болон их засварын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн асуудлыг энэ тайланд тусгаагүй болно. Стандартад нийцсэн байдлын мэдэгдэл: Энэхүү аудитыг Дотоод аудитын дэлхийн стандартад нийцүүлэн гүйцэтгэв. Энэ мэдэгдэл нь дотоод аудитын чанарын баталгаа, сайжруулалтын хөтөлбөрийн үнэлгээний үр дүнд үндэслэсэн болно (Стандарт 4.1, 15.1).
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Шалгуур үзүүлэлтэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан журам, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журам Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”, 2014 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам” болон аймгийн холбогдох бусад шийдвэрийг ашиглав.
Асуудлын ач холбогдлын үнэлгээ:	Илэрсэн асуудлыг Дотоод аудитын дэлхийн стандартын 14.3-т заасны дагуу ач холбогдлоор нь гурван түвшинд ангилав. Үүнд: “**Нөлөө өндөр**” – санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хөрөнгийн хамгаалалтад материаллаг нөлөөтэй, нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай; “**Нөлөө дунд**” – дотоод хяналтын сул тал илэрсэн, тогтоосон хугацаанд залруулах шаардлагатай; “**Нөлөө бага**” – бүртгэлийн техникийн шинжтэй алдаа, дараагийн тайлант хугацаанд залруулах боломжтой.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг ажлын хэсгийн ахлагч, СХШУАБ Т.Мөнхзул, гишүүд: дотоод аудитор Г.Дорждэрэм, Х.Батбаатар, Д.Ванчигмаа, Б.Идэрчулуун нар 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 06-ны өдрийн хооронд гүйцэтгэв. Мэдээллийг гурван эх сурвалжаар байгууллага тус бүрээр тулгах, улсын бүртгэлийн системүүдээс мэдээлэл авч тулгах ажилд удирдамжид заасан хугацаанаас илүү хугацаа шаардагдсан тул аудитын хугацааг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2026 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/22 дугаар тушаалаар 2026 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл сунгасан.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 87 байгууллага (ТШЗ-64, ААТҮГ-23) үйл ажиллагаа явуулж байна. ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар эдгээр байгууллагын үндсэн хөрөнгө 2025 оны жилийн эцсийн байдлаар 204,178.38 сая төгрөг байгаа нь 2024 оны жилийн эцсийн дүнгээс (191,084.82 сая төгрөг) 13,093.56 сая төгрөг буюу 6.9 хувиар өссөн байна.

Шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгө 2024 онд 50,457.70 сая төгрөг байсан бол 2025 онд 44,465.60 сая төгрөг болж, 5,992.10 сая төгрөгөөр буюу 11.9 хувиар буурсан байна.

Хасагдсан хөрөнгө 2024 онд 9,554.81 сая, 2025 онд 18,387.14 сая төгрөг болж 8,832.33 сая төгрөгөөр буюу 92.4 хувиар өссөн нь шилжүүлсэн хөрөнгө 595.72 саяас 7,896.27 сая, “бусад” хэлбэрээр хассан хөрөнгө 2,013.74 саяас 4,628.64 сая төгрөг болж өссөнтэй холбоотой.


Хүснэгт 1. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, 2024–2025 он /сая төгрөг/

Үзүүлэлт	2024 он		2025 он		Зөрүү (2025 − 2024)	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	сая төгрөг	Өөрчлөлт, %
Оны эхний үлдэгдэл (анхны өртөг)	**210,044.25**		**250,947.14**		**40,902.88**	19.5%
Нэмэгдсэн	**50,457.70**	100.0%	**44,465.60**	100.0%	**-5,992.10**	-11.9%
- худалдан авсан	4,513.63	8.9%	3,330.32	7.5%	-1,183.31	-26.2%
- хандиваар	582.16	1.2%	4,559.43	10.3%	3,977.26	683.2%
- шилжүүлэн авсан	16,777.36	33.3%	12,616.89	28.4%	-4,160.47	-24.8%
- бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан	512.45	1.0%	1,028.95	2.3%	516.50	100.8%
- бусад	28,000.04	55.5%	22,918.03	51.5%	-5,082.00	-18.1%
- дахин үнэлгээний нэмэгдэл	72.05	0.1%	11.98	0.0%	-60.08	-83.4%
Хасагдсан	**9,554.81**	100.0%	**18,387.14**	100.0%	**8,832.33**	92.4%
- худалдсан	–	0.0%	5.58	0.0%	5.58	–
- актлалсан	1,254.09	13.1%	1,383.65	7.5%	129.55	10.3%
- шилжүүлсэн	595.72	6.2%	7,896.27	42.9%	7,300.56	1225.5%
- бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн	352.93	3.7%	711.80	3.9%	358.87	101.7%
- бусад	2,013.74	21.1%	4,628.64	25.2%	2,614.90	129.9%
- дахин үнэлгээний хорогдол	5,338.33	55.9%	3,761.20	20.5%	-1,577.13	-29.5%
Оны эцсийн үлдэгдэл (анхны өртөг)	**250,947.14**		**277,025.59**		**26,078.45**	10.4%
Элэгдлийн зардал (тайлант онд)	11,466.41		16,405.01		4,938.60	43.1%
Хуримтлагдсан элэгдэл (оны эцэс)	**59,862.31**		**72,847.21**		**12,984.90**	21.7%
Үлдэх өртөг (оны эцэс)	**191,084.82**		**204,178.38**		**13,093.56**	6.9%

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2024, 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан (5.14 “Үндсэн хөрөнгө”)

ОНӨГ-ын хөрөнгийн нэгдсэн бүртгэлийн системд 2025 оны байдлаар 23,966 нэр төрлийн, 277,420.46 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй бөгөөд үүний 37.5 хувийг нийтийн эзэмшлийн байгууламж, 31.6 хувийг барилга, байгууламж эзэлж байна. Тус системд бүртгэлтэй дүн нь ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн анхны өртгөөс 394.87 сая төгрөгөөр илүү байгаа нь хоёр бүртгэлийн уялдаа бүрэн хангагдаагүйг харуулж байна.

График 1. Үндсэн хөрөнгийн бүтэц (ОНӨГ-ын бүртгэлээр, 2025) /сая төгрөг/



Нийт 277,420.46 сая төгрөг. Ангиллын задаргаагүй дүн: нэгдсэн бүртгэлийн дүн ба ангиллын нийлбэрийн (271,955.19) зөрүү.

Эх сурвалж: ОНӨГ-ын хөрөнгийн нэгдсэн бүртгэл

1.1 ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн үндсэн хөрөнгийн мэдээллийн 2024, 2025 оны харьцуулалт


Үндсэн хөрөнгийн мэдээллийг гурван эх сурвалжаар буюу ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, ОНӨГ-ын хөрөнгийн нэгдсэн бүртгэл, ТШЗ-ийн санхүүгийн тайлангаар байгууллага тус бүрээр тулгаж, 2024, 2025 оны байдлаар харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 2. ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн үндсэн хөрөнгийн дүн, 2024–2025 оны харьцуулалт /сая төгрөг/

Эх сурвалж	Үзүүлэлт	2024 он	2025 он	Зөрүү (сая төгрөг)	Өөрчлөлт, %
ТЕЗ (нэгтгэсэн тайлан)	Анхны өртөг	250,947.14	277,025.59	26,078.45	10.4%
	Хуримтлагдсан элэгдэл	59,862.31	72,847.21	12,984.90	21.7%
	Үлдэх өртөг	191,084.82	204,178.38	**13,093.56**	6.9%
	Хамрагдсан байгууллагын тоо	90	87	-3	
ОНӨГ (нэгдсэн бүртгэл)	Анхны өртөг	233,694.12	277,420.46	43,726.34	18.7%
	Хуримтлагдсан элэгдэл	60,365.92	72,998.59	12,632.67	20.9%
	Үлдэх өртөг	173,328.20	204,421.88	**31,093.68**	17.9%
ТШЗ-ийн санхүүгийн тайлан	Анхны өртөг	243,956.37	277,058.87	33,102.50	13.6%
	Хуримтлагдсан элэгдэл	57,831.44	73,395.81	15,564.37	26.9%
	Үлдэх өртөг	186,124.94	203,663.07	**17,538.13**	9.4%
	Хамрагдсан байгууллагын тоо	74	87	13	

Эх сурвалж: ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан, ОНӨГ-ын нэгдсэн бүртгэл, ТШЗ-ийн санхүүгийн тайлан

График 2. ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн үндсэн хөрөнгийн дүн, 2024–2025 он



ТЕЗ-ийн нэгтгэлээр үндсэн хөрөнгийн анхны өртөг 2024 онтой харьцуулахад 26,078.45 сая төгрөг буюу 10.4 хувиар, үлдэх өртөг 13,093.56 сая төгрөг буюу 6.9 хувиар өссөн бол хуримтлагдсан элэгдэл 21.7 хувиар өссөн нь элэгдлийн өсөлт хөрөнгийн өсөлтөөс давж байгааг харуулж байна. ОНӨГ-ын бүртгэлийн анхны өртөг 43,726.34 сая төгрөг буюу 18.7 хувиар өссөн нь 2024 онд бүртгэлгүй байсан хөрөнгийг 2025 онд цахим системд бүртгэж эхэлсэнтэй холбоотой.

Хүснэгт 3. ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн мэдээллийн зөрүү, 2024–2025 он /сая төгрөг/

Зөрүүний төрөл	2024 он		2025 он		Дүгнэлт
	Байгууллагын тоо	Дүн	Байгууллагын тоо	Дүн	
ТЕЗ − ОНӨГ: анхны өртөг	59	17,253.02	7	-394.87	Зөрүү 97.7%-иар буурсан
ТЕЗ − ОНӨГ: хуримтлагдсан элэгдэл	48	-503.61	16	-151.38	Буурсан
ТЕЗ − ОНӨГ: үлдэх өртөг /санхүүгийн тайлангийн дүн/	56	17,756.62	21	-243.50	Зөрүү 98.6%-иар буурсан, ОНӨГ илүү
ТЕЗ − ТШЗ-ийн тайлан: анхны өртөг	26	6,990.77	2	-33.28	Бараг арилсан
ТЕЗ − ТШЗ-ийн тайлан: хуримтлагдсан элэгдэл	40	2,030.87	12	-548.59	Буурсан
ТЕЗ − ТШЗ-ийн тайлан: үлдэх өртөг /санхүүгийн тайлангийн дүн/	40	4,959.88	12	515.31	Зөрүү 89.6%-иар буурсан, ТШЗ дутуу

Эх сурвалж: Аудиторын тооцоолол (1 мянган төгрөгөөс дээш зөрүүтэй байгууллагыг тоолсон).

ТШЗ-ийн тайлан ба дэлгэрэнгүй бүртгэлийн зөрүү. 2025 онд ТШЗ-ийн санхүүгийн тайланд тусгасан үндсэн хөрөнгийн дүнг тухайн байгууллагын хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгахад 15 байгууллагын тайлан бүртгэлээсээ зөрүүтэй байна. Үүнээс 11 байгууллагын тайланд 429.28 сая төгрөгөөр илүү, 4 байгууллагын тайланд 255.09 сая төгрөгөөр дутуу тусгагдсан бөгөөд цэвэр зөрүү 174.19 сая төгрөг байна. Тухайлбал:


- **Мандал сумын Биеийн тамир, спортын хороо:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 227.48 сая төгрөгөөр бага;
- **Баянгол сумын ЗДТГ:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 189.11 сая төгрөгөөр их;

- **Түшиг сумын ЗДТГ:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 174.86 сая төгрөгөөр их;
- **Аймгийн ЗДТГ:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 26.79 сая төгрөгөөр бага;
- **Мандал сумын ЗДТГ:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 20.00 сая төгрөгөөр их;
- **Баянгол сумын Биеийн тамир, спортын хороо:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 19.69 сая төгрөгөөр их;
- **Алтанбулаг сумын ЗДТГ:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 10.54 сая төгрөгөөр их;
- **Шаамар сумын Дулаанхан тосгоны Захирагчийн алба:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 9.90 сая төгрөгөөр их;
- **Орхон сумын ИТХ:** санхүүгийн тайлангийн үлдэх өртөг дэлгэрэнгүй бүртгэлээс 2.47 сая төгрөгөөр их;

Бусад 6 байгууллагын (Баруунбүрэн сумын Орхоны бүсийн ойн анги, Хушаат сумын ИТХ, Мандал сумын Түнхэл тосгоны Захирагчийн алба, Баянгол сумын ИТХ, Шаамар сумын ЗДТГ, Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн алба) зөрүү тус бүр 2 сая төгрөгөөс бага байна. Энэ нь тайланг бүртгэлийн программаас бус гараар бэлтгэж, дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгадаггүйтэй холбоотой бөгөөд уг асуудлыг 3.1 дүгээр дэд бүлгийн 1.2 дугаар асуудалд тусгав.

Биеийн тамир, спортын хороодын онцлог. ТЕЗ-ийн нэгтгэлд 7 биеийн тамир, спортын хорооны (Мандал, Сайхан, Цагааннуур, Баянгол, Баруунбүрэн, Ерөө сумын Биеийн тамир, спортын хороо, Шаамар сумын Дулаанхан спорт цогцолбор) 2025 оны эцсийн байдлаарх 3,698.67 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэгтгэгдсэн байна. Эдгээр байгууллага орон тооны нягтлан бодогчгүй бөгөөд тухайн сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хавсран гүйцэтгэдэг. Мөн санхүүгийн программ хангамж ашигладаггүй, үндсэн хөрөнгийн бүртгэл, санхүүгийн тайлан, балансыг Excel (xls) файлаар гараар бэлтгэдэг. Тайлан ба дэлгэрэнгүй бүртгэлийн хамгийн их зөрүү (Мандал сумын Биеийн тамир, спортын хороо 227.48 сая төгрөг) эдгээр байгууллагын нэгэнд гарсан байна.

График 3. Үлдэх өртгийн зөрүү, 2024–2025 он /сая төгрөг/



Харьцуулалтаас дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ 2024 онд ОНӨГ-ын нэгдсэн бүртгэл ТЕЗ-ийн нэгтгэлийн дүнгээс 17,756.62 сая төгрөгөөр (56 байгууллага) дутуу байсан бол 2025 онд зөрүү цэвэр дүнгээр 243.50 сая төгрөг (21 байгууллага) болж 98.6 хувиар буурсан нь өмчийн нэгдсэн бүртгэлийн системийг шинэчилсэн ажил үр дүнтэй болсныг харуулж байна. Гэвч 2025 онд ОНӨГ-ын бүртгэлийн дүн ТЕЗ-ийн тайлангаас илүү гарсан нь бүртгэлийн уялдаа бүрэн хангагдаагүйг илтгэнэ.
- ✓ ТЕЗ-ийн нэгтгэл ба ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн дүнгийн зөрүү 4,959.88 сая төгрөгөөс (40 байгууллага) 515.31 сая төгрөг (12 байгууллага) болж буурсан хэдий ч ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн дүн ТЕЗ-ийн нэгтгэлээс бага хэвээр байна.
- ✓ Хуримтлагдсан элэгдлийн зөрүү 2025 онд ТЕЗ-ийн нэгтгэл, ТШЗ-ийн тайлангийн хооронд 548.59 сая төгрөг болж анхны өртгийн зөрүүгээс (33.28 сая төгрөг) их байгаа нь элэгдэл тооцох аргачлал, ашиглалтын хугацаа байгууллага бүрт өөр байгаатай холбоотой. */Байгууллага тус бүрийн зөрүүг Хавсралт 2-т дэлгэрэнгүй харуулав/*

2. АУДИТЫН ҮР ДҮН

2.1 Аудитын дүгнэлт

Аудитын нийт дүгнэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын дотоод хяналт хангалтгүй байна. Аудитаар 29,755.31 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий 11 төрлийн, мөнгөн дүнгүй 3 төрлийн зөрчил илэрсний 6 нь өндөр нөлөөтэй байна. Нөгөө талаар ОНӨГ-ын нэгдсэн бүртгэл ТЕЗ-ийн нэгтгэлтэй уялдах байдал 2024 оноос мэдэгдэхүйц сайжирч, зөрүү 98.6 хувиар буурсныг эерэг үр дүн гэж үнэлэв.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан, ОНӨГ-ын нэгдсэн бүртгэл, ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн мэдээлэл хоорондоо уялдаагүй, 2024 онд ОНӨГ-ын бүртгэл ТЕЗ-ийн нэгтгэлээс 17,756.62 сая төгрөгөөр дутуу байсан бол 2025 онд зөрүү 98.6 хувиар буурч 243.50 сая төгрөг болсон хэдий ч бүрэн арилаагүй байна.
2. ТЕЗ-ийн нэгтгэлд ТШЗ-ийн тайлангаас илүү дүн тусгагдсан (2025 онд 515.31 сая төгрөг) бөгөөд нэгтгэсэн тайланг байгууллагын тайлантай тулгаж баталгаажуулах хяналт хангалтгүй байна.
3. ТШЗ-ийн санхүүгийн тайлан өөрийн дэлгэрэнгүй бүртгэлээр нотлогдохгүй, тайланг бүртгэлээс автоматаар бус гараар бэлтгэж байна.
4. Эзэмшлийн газар, тээврийн хэрэгслийг улсын бүртгэлийн мэдээлэлтэй тогтмол тулгадаггүйгээс 197 газар, 19 тээврийн хэрэгсэл хөрөнгийн бүртгэлд тусгагдаагүй, харин улсын бүртгэлд бүртгэлгүй 30 газар, 113 тээврийн хэрэгслийг хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.
5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оноос хойш шинэчлээгүй, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг нэгдсэн байдлаар тогтоогоогүй байна.
6. Үндсэн хөрөнгийг дансны жишиг жагсаалтын дагуу ангилах, бүрэлдэхүүн хэсгээр нь салгаж бүртгэх, их засварыг капиталжуулах, хэмжих нэгжийг зөв тодорхойлох ажил стандартын дагуу хийгдээгүй байна.

7. Дуусаагүй барилга, байгууламжийн бүртгэлд 3–15 жил хөдөлгөөнгүй, давхар бүртгэгдсэн, барилга биш хөрөнгө бүртгэгдсэн бөгөөд хуучирсан 39216 дансыг ашигласаар байна.
8. Элэгдлээ бүрэн нөхсөн 5,931.56 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэх, данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг ОНӨГ болон байгууллагууд зохион байгуулаагүй байна.
9. Элэгдлийг программаар автоматаар тооцдог хэдий ч хяналт тавиагүйгээс сөрөг үлдэх өртөг, газрын элэгдэл тайланд тусгагдсан байна.
10. Тусгай сангийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө олж бэлтгэж, сангийн тайланд бүртгэсэн нь сангийн зориулалтыг алдагдуулж байна.
11. Үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьдаг дөрвөн байгууллага, мэдээлэл эзэмшигч ГХБХБГ, АТҮТ, татварын алба хоорондын мэдээлэл солилцоо, шийдвэр гаргах хугацаа тодорхойгүйгээс зөрчлийн ихэнхийг байгууллага дангаараа залруулах боломжгүй байна. Мөн мал, биологийн хөрөнгийг тооллоготой тулгаж бүртгэх журам тогтоогоогүй байна.

2.2 Илэрсэн зөрчлийн нэгтгэл


Аудитаар нийт 29,755.31 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий 11 төрлийн, мөнгөн дүнгүй 3 төрлийн, нийт 14 төрлийн зөрчил илрүүлж, бүгдэд нь зөвлөмж өгч, хариуцах эзэн, холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт 4. Илэрсэн зөрчлийн нэгтгэл

д/д	Зөрчлийн утга	Байгууллагын тоо	Дүн (сая төгрөг)	Хариуцах эзэн
1.1	ТЕЗ, ОНӨГ, ТШЗ-ийн мэдээллийн зөрүү (2025)	21/12	758.81	ТЕЗ, ОНӨГ
1.2	Санхүүгийн тайлан дэлгэрэнгүй бүртгэлээс зөрүүтэй	15	174.19	ТШЗ
1.3	Газрын бүртгэл зөрүүтэй	30	-	ТШЗ, ААТҮГ, ОНӨГ
1.4	Тээврийн хэрэгслийн бүртгэл зөрүүтэй	49	-	ТШЗ, ААТҮГ, ОНӨГ
1.5	НББ-ийн бодлогын баримт бичиг шинэчлээгүй	1	-	ТЕЗ
2.1	Дансны ангилал буруу бүртгэсэн	38	12,922.10	ТШЗ, ААТҮГ
2.2	Төсөл арга хэмжээний нэрээр болон дүнгээр бүртгэсэн	13	3,319.12	ТШЗ, ААТҮГ
2.3	Их засварыг капиталжуулаагүй	18	2,876.82	ТШЗ, ААТҮГ
2.4	Хэмжих нэгж бичээгүй, буруу	22	1,895.28	ТШЗ, ААТҮГ
2.5	Бараа материалыг ҮХ-д бүртгэсэн	22	11.21	ТШЗ, ААТҮГ
2.6	ДҮ (39216) дансны бүртгэл бодит бус	8	1,820.92	Сумын ЗДТГ, ОНӨГ
2.7	Тусгай санд үндсэн хөрөнгө бүртгэсэн	6	22.47	ТШЗ
3.1	Элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгө	48	5,931.56	ТШЗ, ААТҮГ, ОНӨГ
3.2	Сөрөг элэгдэл, газар элэгдүүлсэн	12	22.81	ТШЗ
	Нийт		**29,755.29**	

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

График 4. Илэрсэн зөрчил төрлөөр /сая төгрөг/



Нийт 29,755.31 сая төгрөг (мөнгөн дүн бүхий 11 төрөл). Мөнгөн дүнгүй: 1.3 Газар, 1.4 Тээврийн хэрэгсэл, 1.5 НББ-ийн бодлого.

3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ

Аудитаар илэрсэн 14 асуудлыг аудитын зорилт тус бүрээр доор харуулав.

3.1 Зорилт 1. Үндсэн хөрөнгийн нэгтгэсэн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдал хангагдаагүй байна

Илэрсэн асуудал: 1.1	ТЕЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэх өртгөөс ОНӨГ-ын нэгдсэн бүртгэлийн дүн 243.50 сая төгрөгөөр илүү, ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн дүн 515.31 сая төгрөгөөр дутуу буюу нийт 758.81 сая төгрөгөөр зөрүүтэй зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө өндөр**
Бодит байдал:	ТЕЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэх өртгөөс ОНӨГ-ын нэгдсэн бүртгэлийн дүн 243.50 сая төгрөгөөр илүү (21 байгууллага), ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн дүн 515.31 сая төгрөгөөр дутуу (8 ТШЗ-д 426.22 сая, 4 ААТҮГ-т 89.09 сая төгрөг) буюу нийт 758.81 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь ... жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, ...”, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ын 27 дугаарт “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, ... үнэн зөв толилуулах ёстой.”, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ын 15 дугаарт “Санхүүгийн тайлан нь аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, ... үнэн зөв толилуулна.”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын 2.4-ийн (б)-д “санхүүгийн тайланд

	төсвийн байгууллагын санхүүгийн байдал, ... үнэн зөв толилуулна.”, Аймгийн Засаг даргын 2023 оны А/587 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн газрын дүрэм”-ийн 2.9-д “Өмчийн өөрчлөлтийн бүртгэлийг хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах үйл ажиллагаанд хяналт тавих ...”, 2.11-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн болон хөрөнгийн мэдээ, тайланг хүлээн авч нэгтгэх, нэгдсэн тайлан боловсруулах ...”, Аймгийн Засаг даргын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/206 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5-д “... аж ахуйн нэгж байгууллагуудын ... жилийн эцсийн тайланг хянаж баталгаажуулах, ... төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан хүлээн авах ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	ТЕЗ нэгтгэсэн тайлан хүлээн авахдаа ТШЗ-ийн санхүүгийн тайланг ОНӨГ-ын бүртгэл, дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгах шалгуургүй; гурван бүртгэл өөр өөр программд, мэдээлэл автоматаар солилцдоггүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн мэдээлэл ОНӨГ болон харьяа байгууллагуудын бүртгэлээр баталгаажихгүй, орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэлгүй хөрөнгө эзэнгүйдэх, тайлан бодит бус гарах эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Дэлгэрэнгүй бүртгэлийг үндсэн эх сурвалж болгож, ТШЗ–ОНӨГ–ТЕЗ гурвалсан тулгалтын актаар эхний үлдэгдлийг залруулах (УСНББОУС 3); нэгтгэсэн тайлан хүлээн авахад тулгалтын актыг заавал шаардах.

/Хүснэгт 2, 3, Хавсралт 2-т дэлгэрэнгүй харуулав/

Илэрсэн асуудал: 1.2	15 ТШЗ-ийн аудитлагдсан санхүүгийн тайланд тусгасан үндсэн хөрөнгийн дүн дэлгэрэнгүй бүртгэлээсээ цэвэр дүнгээр 174.19 сая төгрөгөөр (429.28 сая төгрөгөөр илүү, 255.09 сая төгрөгөөр дутуу) зөрүүтэй зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө дунд**
Бодит байдал:	15 ТШЗ-ийн аудитлагдсан санхүүгийн тайланд тусгасан үндсэн хөрөнгийн үлдэх өртөг тухайн байгууллагын хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 174.19 сая төгрөгөөр зөрүүтэй, мөн 6 байгууллагын анхны өртөг 208.54 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв ... бүртгэж, тайлагнах”, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ын 27 дугаарт “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, ... үнэн зөв толилуулах ёстой.”, Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын 2.4-ийн

	(б)-д “санхүүгийн тайланд төсвийн байгууллагын санхүүгийн байдал, ... үнэн зөв толилуулна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Санхүүгийн тайланг бүртгэлийн программаас автоматаар бус гараар бэлтгэж, дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгадаггүй; ТЕЗ тайлан хүлээн авахдаа тулгалт шаарддаггүй. Ялангуяа биеийн тамир, спортын 7 хороо орон тооны нягтлан бодогчгүй, сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хавсран ажилладаг, санхүүгийн программгүй тул бүртгэл, тайлан, балансаа Excel файлаар гараар хөтөлдөг.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Санхүүгийн тайлан дэлгэрэнгүй бүртгэлээр нотлогдохгүй, хөрөнгийн хөдөлгөөн бүртгэлд бүрэн тусгагдаагүй байх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** санхүүгийн тайланг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгаж зөрүүг залруулах, тайланг бүртгэлээс бэлтгэж тулгалтын хуудсыг хавсаргах. Биеийн тамир, спортын хороодын үндсэн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн программд шилжүүлж, хавсран гүйцэтгэж буй нягтлан бодогчийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох.

Илэрсэн асуудал: 1.3	Газрын нэгдсэн бүртгэлийн систем (ХУР) болон ОНӨГ-ын бүртгэлтэй тулгахад нийт 30 байгууллагын (ТШЗ-25, ААТҮГ-5) эзэмших эрхтэй газрын бүртгэл зөрүүтэй буюу 27 байгууллагын бүртгэл ХУР системийн мэдээллээс 227 газраар, 13 байгууллагын бүртгэл ОНӨГ-ын бүртгэлээс 85 газраар зөрүүтэй (үүнээс 3 байгууллага зөвхөн ОНӨГ-ын бүртгэлтэй зөрүүтэй) зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө өндөр**
Бодит байдал:	Байгууллагуудын эзэмших эрхтэй газрын бүртгэлийг Газрын нэгдсэн бүртгэлийн системийн мэдээлэлтэй тулгахад 27 байгууллагын (ТШЗ-22, ААТҮГ-5), ОНӨГ-ын бүртгэлтэй тулгахад 13 байгууллагын бүртгэл зөрүүтэй буюу давхардсан тоогоор нийт 30 байгууллагын (ТШЗ-25, ААТҮГ-5) газрын бүртгэл зөрүүтэй байна. Үүнд: • 20 байгууллага (ТШЗ-17, ААТҮГ-3) эзэмших эрхтэй 197 газрыг үнэлж, хөрөнгийн бүртгэл, санхүүгийн тайландаа тусгаагүй; • 7 байгууллага (ТШЗ-5, ААТҮГ-2) Газрын нэгдсэн бүртгэлийн системд бүртгэлгүй 30 газрыг хөрөнгийн бүртгэлдээ бүртгэсэн; • ОНӨГ-ын бүртгэлтэй тулгахад 13 байгууллагын (ТШЗ-12, ААТҮГ-1) газрын тоо зөрүүтэй (11 байгууллагад 24 газраар илүү, 2 байгууллагад 61 газраар дутуу) байна. Санхүүгийн тайланд нийт 285 газар (19 ТШЗ-д 235 газар 11,783.32 сая төгрөг, 6 ААТҮГ-т 50 газар 3,392.04 сая төгрөг) тайлагнагдсан байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т нягтлан бодох бүртгэлд “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг заавал бүртгэх, 12 дугаар зүйлийн 12.2.1-д хөрөнгө, төлбөр тооцооны

	тооллогыг “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” заавал хийх, 20.2.6-д “эд хөрөнгийн ... тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.8-д “... Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.”, Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/587 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн газрын дүрэм”-ийн 2.9-д “Өмчийн өөрчлөлтийн бүртгэлийг хөтлөх, ... мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах үйл ажиллагаанд хяналт тавих ...”, 2.10-т “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, улсын дүн нэгтгэх тайлагнах, бүртгэлээр хяналт тавих” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Газар эзэмших эрх олгосон, цуцалсан шийдвэр нягтлан бодогчид албан ёсоор ирдэггүй, кадастрын дугаараар холбогдсон бүртгэлгүй; газрыг үнэлж бүртгэх шийдвэрийг ТӨБЗГ гаргадаг тул ТШЗ өөрөө үнэлэх эрхгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Орон нутгийн өмчийн газар санхүүгийн тайланд бүрэн илэрхийлэгдэхгүй, газрын эрх зүйн хамгаалалт алдагдах, давхар болон бүртгэлгүй газар үүсэх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** ОНӨГ нь ГХБХБГ-аас байгууллага тус бүрийн эзэмшлийн газрын жагсаалтыг авч нэгтгэн ТӨБЗГ-т санал хүргүүлж үнэлүүлэх (271-р тогтоолын 3.8); системд бүртгэлгүй газрын эрх зүйн байдлыг тодруулах.

/Байгууллага тус бүрийг Хавсралт 4-т харуулав/

Илэрсэн асуудал: 1.4	ТЕЗ-ийн эрхлэх хүрээний 49 байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл Авто тээврийн үндэсний төвийн мэдээллээс 132, татварын албаны мэдээллээс 133, ОНӨГ-ын бүртгэлээс 11 тээврийн хэрэгслээр зөрүүтэй зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө өндөр**
Бодит байдал:	Байгууллагуудын хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг АТҮТ болон татварын албаны мэдээлэлтэй тулгахад: • АТҮТ-ийн мэдээллээс 38 байгууллагын (ТШЗ-25, ААТҮГ-13) бүртгэл зөрүүтэй бөгөөд 31 байгууллага (ТШЗ-20, ААТҮГ-11) АТҮТ-ийн системд бүртгэлгүй 113 тээврийн хэрэгслийг бүртгэсэн, 7 байгууллага (ТШЗ-5, ААТҮГ-2) 19 тээврийн хэрэгслийг хөрөнгийн бүртгэлд тусгаагүй;

	• Татварын албаны мэдээллээс 46 байгууллагын (ТШЗ-32, ААТҮГ-14) бүртгэл зөрүүтэй (36 байгууллагад 113 тээврийн хэрэгслээр илүү, 10 байгууллагад 20 тээврийн хэрэгслээр дутуу); • ОНӨГ-ын бүртгэлээс 5 байгууллагын 11 тээврийн хэрэгслээр зөрүүтэй (2 байгууллагад 6 тээврийн хэрэгслээр илүү, 3 байгууллагад 5 тээврийн хэрэгслээр дутуу) байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т нягтлан бодох бүртгэлд “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг заавал бүртгэх, Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/587 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн газрын дүрэм”-ийн 2.9-д “Өмчийн өөрчлөлтийн бүртгэлийг хөтлөх, ... мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах үйл ажиллагаанд хяналт тавих ...”, 2.10-т “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, улсын дүн нэгтгэх тайлагнах, бүртгэлээр хяналт тавих” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Акталж хассан, шилжүүлсэн тээврийн хэрэгслийг АТҮТ, татварын бүртгэлээс хасуулаагүй, шилжиж ирснийг улсын бүртгэлд шилжүүлээгүй; гурван систем арлын болон улсын дугаараар тулгагддаггүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Бүртгэлгүй тээврийн хэрэгсэл хяналтаас гадуур ашиглагдах, эзэнгүйдэх, тээврийн хэрэгслийн албан татвар, даатгалын төлбөр зөрүүтэй ногдох эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** ОНӨГ нь АТҮТ, татварын хэлтсээс жагсаалт авч биет тооллогоор тулган баталгаажуулах, бүртгэлгүй хэрэгслийг бүртгэлд авах, акталсныг улсын бүртгэлээс хасуулах.

/Байгууллага тус бүрийг Хавсралт 5-д харуулав/

Илэрсэн асуудал: 1.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оноос хойш хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлээгүй байна.
Асуудлын ангилал:	**Нөлөө дунд**
Бодит байдал:	Аймгийн Засаг даргын 2021 оны 58 дугаар захирамжаар батлагдсан төсөвт байгууллага болон ААТҮГ-уудын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” болон бусад хууль тогтоомж, стандартын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлээгүй, үндсэн хөрөнгийн анги тус бүрийн ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг нэгдсэн байдлаар тогтоогоогүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, журамд нийцүүлэн бодлогын баримт бичгийг баталж,

	мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2, УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ийн 88 дахь заалтуудыг зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар журам шинэчлэгдсэний дараа бодлогын баримт бичгийг хянах үүрэг, хугацааг тогтоогоогүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Байгууллага бүр элэгдлийн хугацааг өөр өөрөөр тогтоож, ижил хөрөнгийн үнэлгээ, элэгдэл зөрүүтэй тооцогдож, нэгтгэсэн тайлангийн харьцуулагдах чанар алдагдана. Мөн ямар ангилалд ямар хөрөнгө бүртгэх нь тодорхойгүй болно.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Бодлогын баримт бичгийг холбогдох хууль, журам болон А/3 тушаалд нийцүүлэн шинэчилж, хөрөнгийн ангилал, ашиглалтын хугацаа, хэмжих нэгжийн нэгдсэн жагсаалт, мал, биологийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийг тусгаж Аймгийн Засаг даргын захирамжаар батлуулах.

3.2 Зорилт 2. Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх, ангилах, үнэлэх ажил стандарт, журмын дагуу хийгдээгүй байна

Илэрсэн асуудал: 2.1	ТЕЗ-ийн харьяа 38 байгууллага 12,922.10 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу дансанд ангилж бүртгэсэн зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө өндөр**
Бодит байдал:	ТЕЗ-ийн харьяа 38 байгууллага (ТШЗ-28, ААТҮГ-10) 12 дансанд 334 нэр төрлийн 12,922.10 сая төгрөгийн хөрөнгийг өөр өөр дансанд бүртгэсэн (ТШЗ-д 242 нэр төрлийн 9,859.60 сая, ААТҮГ-т 92 нэр төрлийн 3,062.50 сая төгрөг) байна. Тухайлбал: зам, гүүрийн байгууламжийн дансанд гэрэлтүүлэг, худаг, хашаа; батлан хамгаалахын тоног төхөөрөмжийн дансанд ном, гарын авлага; бусад үндсэн хөрөнгийн дансанд ус цэвэршүүлэх төхөөрөмж зэргийг бүртгэсэн.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т "Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.", 4.2.4-т 4.1.1-д заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж" заавал мөрдөх, 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) 17 "Үндсэн хөрөнгө"-ийн 52-т "Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төстэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг юм.", Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 16 "Үндсэн хөрөнгө"-ийн 37-д үндсэн хөрөнгийг ижил шинж чанар, хэрэглээ бүхий ангиар бүлэглэх, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын

	1.3-т “Төсвийн байгууллага нь ... гуравдугаар хавсралтаар баталсан “Дансны жишиг жагсаалт”-ыг ... дагаж мөрдөнө.”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.4-т “... эд хөрөнгийг ... үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Бүртгэлээр тавих хяналт сул, хөрөнгийг “Дансны жишиг жагсаалт”-ын өөрчлөлтийн дагуу дахин ангилаагүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Хөрөнгийн ангилал буруу тогтоогдсоноор элэгдлийн хугацаа, норм буруу илэрхийлэгдэж, санхүүгийн тайлангийн тодруулгын мэдээлэл бодит бус гарна.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн ангиллыг шинэчилж (хөрөнгийн нэр, данс, хэмжих нэгж, ашиглах хугацаа) данс хооронд дахин ангилж, 2026 оны тооллогын актаар залруулах.

Илэрсэн асуудал: 2.2	ТЕЗ-ийн нийт 13 байгууллагын (ТШЗ-11, ААТҮГ-2) 29 нэр төрлийн 3,319.12 сая төгрөгийн хөрөнгийг (“ажлын ширээ ба нөөшлөх шилэн сав”, “1900 м бетон замыг асфальтаар хучих”, “2.9 км дугуйн зам” гэх мэт) нэр төрлөөр нь салгалгүй төсөл, арга хэмжээний дүнгээр бүртгэсэн зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө өндөр**
Бодит байдал:	ТЕЗ-ийн харьяа 13 байгууллага (ТШЗ-11, ААТҮГ-2) нийт 29 нэр төрлийн 3,319.12 сая төгрөгийн хөрөнгийг бүрэлдэхүүн хэсгээр нь салгалгүй бүртгэсэн бөгөөд үүнээс: • 11 байгууллага (ТШЗ-9, ААТҮГ-2) 19 нэр төрлийн 2,877.34 сая төгрөгийн өөр өөр шинж чанартай хөрөнгийг нэгтгэж бөөн дүнгээр; • 5 байгууллага (ТШЗ-4, ААТҮГ-1) 10 нэр төрлийн 441.78 сая төгрөгийн хөрөнгийг “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг”, “Гудамжны зам сайжруулах” гэх мэт төсөл, арга хэмжээний нэрээр бүртгэсэн байна. Бусад зөрчилтэй давхардсан бүртгэлийг энэ дүнгээс хассан болно.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.”, 4.2.4-т 4.1.1-д заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” заавал мөрдөх, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.”, УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийн

	59-д “Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ.”, НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 43-т мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлэх, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 5.4.4-т “Зохих журмын дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх үнэлгээг гарган, ашиглалтад авах Ажлын хэсгийн акт, дүгнэлтэд тусгах”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 1.3-т “Төсвийн байгууллага нь ... гуравдугаар хавсралтаар баталсан “Дансны жишиг жагсаалт”-ыг ... дагаж мөрдөнө.”, 10.21-д “Үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “... хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан ... зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Гүйцэтгэгч, захиалагчаас ажлын үнийн задаргаа ирдэггүй, ашиглалтад авах комиссын актад хөрөнгийн бүрэлдэхүүн, нэгж үнэ заагддаггүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийн ашиглалтын хугацаа ялгаатай (жишээ нь гэрэлтүүлгийн шон, замын хучилт) байхад нэг хугацаагаар элэгдүүлэх, тооллогоор биет байдлыг тогтоох боломжгүй болно.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Гүйцэтгэлийн акт, төсвийн задаргаагаар хөрөнгийг бүрэлдэхүүн хэсэг, нэр төрлөөр салгаж, тус бүрт ашиглалтын хугацаа тогтоож дахин бүртгэх, ашиглалтад авах актад задаргааг заавал тусгах.

Илэрсэн асуудал: 2.3	ТЕЗ-ийн харьяа 18 байгууллага хөрөнгө оруулалтаар хийсэн 2,876.82 сая төгрөгийн их засварыг холбогдох хөрөнгийн өртөгт нэмж капиталжуулаагүй хөрөнгөөр бүртгэсэн зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө дунд**
Бодит байдал:	ТЕЗ-ийн харьяа 18 байгууллага (ТШЗ-16, ААТҮГ-2) хөрөнгийн чанарыг сайжруулж, ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор хөрөнгө оруулалтаар хийсэн 42 нэр төрлийн 2,876.82 сая төгрөгийн их засварыг (“Наадмын талбайн тохижилт”, “Засварын ажил (дээвэр, шал)”, “Барилгын засвар”, “Халуун усны барилгын засвар” гэх мэт) холбогдох үндсэн хөрөнгийн өртөгт нэмэгдүүлэлгүй тусдаа хөрөнгөөр бүртгэсэн байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.”, 4.2.4-т 4.1.1-д заасан

	Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” заавал мөрдөх, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 24-т “... байгууллага нь ийм зүйлсийн орлуулан нэмэгдэж буй хэсгийг хэрэв хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал тухайн өртөг зардал гарсан үед үндсэн хөрөнгийн дансны үнэд оруулан хүлээн зөвшөөрнө. ...”, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 13-т “... аж ахуйн нэгж нь үндсэн хөрөнгийн зүйлийн хэсгийг орлуулах өртгийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал тухайн зүйлийн дансны үнэд хүлээн зөвшөөрнө ...”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.46-д “Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа үед гарсан зардал нь хөрөнгийн ерөнхий чанарыг сайжруулж, анх тогтоосон бүтээмжийг дээшлүүлж, байгууллагын ирээдүйд хүртэх өгөөжийг нэмэгдүүлж байвал ийм зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулж бүртгэнэ.”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “... хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан ... зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Ашиглалтад авах комиссын актад засварыг аль хөрөнгийн өртөгт нэмэх (хөрөнгийн код, үнэ) заагддаггүй; их засвар, урсгал засварыг ялгах шалгуур бодлогын баримт бичигт байхгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Үндсэн хөрөнгийн өртөг, ашиглалтын хугацаа бодитоор тусгагдахгүй, засвар хийгдсэн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн мэт харагдах, акталж данснаас хасах үед засварын дүн бүртгэлд үлдэх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Их засварыг акт, төсвийн задаргаагаар холбогдох хөрөнгийн өртөгт нэмж, ашиглалтын хугацааг шинэчлэх; хэвийн байдлыг сэргээх засварыг зардлаар хүлээн зөвшөөрөх. Хариуцах: ТШЗ, ААТҮГ; шийдвэр гаргахад оролцох: ОНӨГ, ашиглалтад авах комисс.

Илэрсэн асуудал: 2.4	ТЕЗ-ийн харьяа 22 байгууллага 1,895.28 сая төгрөгийн хөрөнгийн хэмжих нэгжийг бичээгүй, эсхүл буруу (“1”, “дүн” гэх мэт) бүртгэсний улмаас нэгжийн өртөг тодорхойгүй болсон зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө дунд**
Бодит байдал:	22 байгууллага (ТШЗ-16, ААТҮГ-6) 135 нэр төрлийн 1,895.28 сая

	төгрөгийн хөрөнгийн хэмжих нэгжийг бичээгүй, эсхүл хөрөнгийн шинж чанарт нийцэхгүй байдлаар (зам засварт “литр”, “метр” бичиж тоо хэмжээг “1”, хэмжих нэгжгүйгээр “0.94” гэх мэт) бүртгэсэн тул нэгжийн өртгийг тодорхойлох боломжгүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 12 дугаар зүйлийн 12.2.1-д хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” заавал хийх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв ... бүртгэж, тайлагнах”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “... хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан ... зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Хэмжих нэгжийн нэгдсэн жагсаалтгүй, программд хэмжих нэгжийг заавал бөглөх хяналт тохируулаагүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Тооллогоор хөрөнгийн тоо хэмжээг бүртгэлтэй тулгах, дутагдал, илүүдлийг тогтоох боломжгүй болно.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор тоо хэмжээ, хэмжих нэгжийг тогтоож засварлах.

Илэрсэн асуудал: 2.5	ТЕЗ-ийн харьяа 22 байгууллагын (ТШЗ-17, ААТҮГ-5) үндсэн хөрөнгийн дансанд 70 нэр төрлийн 11.21 сая төгрөгийн (компьютерын дагалдах хэрэгсэл, цахилгааны жижиг хэрэгсэл, хөшиг, хувцас гэх мэт) бараа материалыг бүртгэсэн зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө бага**
Бодит байдал:	22 байгууллага (ТШЗ-17, ААТҮГ-5) үндсэн хөрөнгийн дансанд компьютерын дагалдах хэрэгсэл, цахилгааны жижиг хэрэгсэл, хөшиг, спортын хувцас зэрэг 70 нэр төрлийн 11.21 сая төгрөгийн бараа материалыг бүртгэсэн байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.”, 4.2.4-т 4.1.1-д заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” заавал мөрдөх, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 14-т “Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: (а) ... ирээдүйн

	эдийн засгийн үр өгөөж ... тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх ...", УСНББОУС 12 "Бараа материал"-ын 9-д бараа материал гэдэг нь "... (б) Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах ... хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа" хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 16 "Үндсэн хөрөнгө"-ийн 7-д "Үндсэн хөрөнгийн зүйлийн өртгийг ... ирээдүйн эдийн засгийн үр өгөөж ... орох магадлалтай ... тохиолдолд л хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-т "Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ.", 10.6-д "Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн ... хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Худалдан авалтыг бүртгэхдээ үндсэн хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг (ашиглалтын хугацаа, үнийн босго) хянадаггүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл хийсвэрээр өсөж, ашиглагдаж дууссан бараа материал дансанд үлдэх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Бараа материалыг холбогдох дансанд шилжүүлж, ашиглагдаж дууссаныг зарлагадах. Хариуцах: ТШЗ, ААТҮГ.

/Байгууллага тус бүрийн дүнг Хавсралт 1-д харуулав/

Илэрсэн асуудал: 2.6	ТЕЗ-ийн харьяа 8 байгууллага 39216 "Дуусаагүй барилга, байгууламж" дансанд 24 нэр төрлийн 1,820.92 сая төгрөгийн хөрөнгийг бодит бусаар бүртгэсэн зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө дунд**
Бодит байдал:	8 байгууллагын (сумын ЗДТГ-6, тосгоны Захирагчийн алба-2) 39216 дансанд бүртгэлтэй 24 нэр төрлийн 1,820.92 сая төгрөгийн хөрөнгийг тулгахад: Мандал сумын Түнхэл тосгоны спорт заал (1,047.57 сая төгрөг, 2012 он), Мандал сумын хүүхдийн тоглоомын талбай (319.74 сая төгрөг, 2021 он) зэрэг барилга, байгууламж олон жилийн турш тус дансанд хөдөлгөөнгүй бүртгэлтэй байна; Ерөө сумын ЗДТГ биет хөрөнгө биш "Сумын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г (79.20 сая төгрөг) 2023, 2025 онд давхар бүртгэсэн; камержуулалт, смарт индэр зэрэг тоног төхөөрөмж, тохижилтын зардлыг барилга, байгууламжийн дансанд бүртгэсэн; шинэчлэгдсэн "Дансны жишиг жагсаалт"-д нийцээгүй 39216 дансыг ашигласаар байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 1.3-т "Төсвийн байгууллага нь ... гуравдугаар хавсралтаар баталсан "Дансны жишиг жагсаалт"-ыг ... дагаж мөрдөнө.", 10.45 дахь заалтуудыг тус тус

	зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Ашиглалтад орсон барилга, байгууламжийг холбогдох дансанд шилжүүлэх, дансны жишиг жагсаалтын өөрчлөлтийг бүртгэлд тусгах хяналт хэрэгжээгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Ашиглалтад орсон хөрөнгөд элэгдэл тооцогдохгүй, давхар бүртгэлээр үндсэн хөрөнгийн дүн хийсвэрээр өсөж, санхүүгийн тайлан бодит бус гарах эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Үзлэгээр бодит байдлыг тогтоож ашиглалтад оруулах, эсхүл бүртгэлээс хасах; давхар бүртгэлийг хасах; 39216 дансны үлдэгдлийг жишиг дансанд шилжүүлэх (Хүснэгт 6).

/Хөрөнгө тус бүрийг Хавсралт 3-т харуулав/

Илэрсэн асуудал: 2.7	6 ТШЗ-ийн орон нутгийн хоршоог хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд сангийн хөрөнгөөр болон бусад эх үүсвэрээр 15 нэр төрлийн 22.47 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө бага**
Бодит байдал:	6 ТШЗ орон нутгийн хоршоог хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд сангийн хөрөнгөөр болон бусад эх үүсвэрээр олж бэлтгэсэн 15 нэр төрлийн 22.47 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” (2022 оны А/243, 2023 оны А/521 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан)-ын 1.5-д “Сангийн хөрөнгө нь ... хөнгөлөлттэй зээл олгох, сургалт зохион байгуулах, хяналт тавих, авлага барагдуулах, урамшуулал олгоход зориулагдана.”, 2.8-д “Энэхүү журмын 1.5, 2.7-д зааснаас бусад зориулалтаар сангийн хөрөнгийг ... зарцуулахыг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Сангийн хөрөнгийн зориулалтыг хязгаарласан журмын заалтыг мөрдөөгүй, сангийн зарцуулалтад сангийн зөвлөлийн хяналт сул.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Сангийн хөрөнгө зориулалтын бусаар зарцуулагдаж, зээлийн эх үүсвэр буурах, хөрөнгө эзэмшигч байгууллагын бүртгэлд тусгагдахгүй байх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** 2026 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар хөрөнгийг ашиглаж буй ЗДТГ-ын балансад шилжүүлэх. Хариуцах: ТШЗ, сангийн зөвлөл.

Бусад асуудал (зөрчлөөр тооцоогүй): Хөрөнгө тус бүрээр тулган баталгаажуулахад 24 байгууллага (ТШЗ-19, ААТҮГ-5) хэвийн байдлыг сэргээх засвар, тохижилтын (924.06 сая), бараа материал, шугам сүлжээний материалын (425.81 сая), иргэн, айл өрхийн өмчид зарцуулсан (222.95 сая), зураг төсөл, ТЭЗҮ, судалгааны (199.61

сая) зэрэг хөрөнгийн шинжгүй 111 нэр төрлийн, анхны өртгөөр 1,780.62 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна. Эдгээрийг орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлээс хасах, холбогдох дансанд шилжүүлэх эсэхийг Орон нутгийн өмчийн газар шийдвэрлэх тул энэ аудитаар зөрчилд тооцоогүй бөгөөд хөрөнгө тус бүрийн жагсаалтыг албан тоотоор Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Гэрэлтүүлгийн жижиг хэсгүүдийг тус бүрээр салгаж бүртгэсэн асуудал: Нэг тендерээр, нэг гүйцэтгэлийн ажлаар хийгдсэн гудамж, талбайн гэрэлтүүлгийг толгой гэрэл, тулгуур шон, кабель, тоолуурын самбар зэрэг эд анги тус бүрээр нь салгаж үндсэн хөрөнгөөр бүртгэсэн тохиолдол байна. Тухайлбал, Цагааннуур сумын ЗДТГ нэг тендерээр гүйцэтгүүлсэн гэрэлтүүлгийн ажлыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 0000013 дугаар орлогын баримтаар 39214 “Бусад үндсэн хөрөнгө” дансанд толгой гэрэл (106 ш, 53.00 сая), тулгуур шон (106 ш, 106.00 сая), сип кабель (4,051 ш, 101.28 сая), 0.4 кВ-ын шугам (10 ш, 10.13 сая), тоолуурын самбар (4 ш, 6.01 сая) гэсэн 5 нэр төрлийн, нийт 4,277 нэгж, 276.41 сая төгрөгөөр салгаж бүртгэсэн байна. Ингэж салгаснаар лонх, сип кабель, утас зэрэг бие даан ашиглагдах боломжгүй эд анги нь бараа материалын шинжтэй болж, хөрөнгийн шинжээ алдаж байгаа бөгөөд тооллогоор тоо хэмжээг тулгах, нэгжийн өртгийг тодорхойлоход хүндрэлтэй (жишээ нь сип кабелийг метрээр бус “ширхэг”-ээр бүртгэсэн) болж байна. Энэ нь 2.2-т дурдсан бүрэлдэхүүн хэсгээр салгах шаардлагатай зөрчилдөхгүй: салгаж бүртгэх нь мэдэгдэхүйц өртөгтэй, ашиглалтын хугацаа нь ялгаатай бие даасан хэсгүүдэд хамаарах бөгөөд бие даасан хөрөнгийн шинжгүй эд ангид хамаарахгүй. Гэрэлтүүлэг нь бүх эд ангиараа хамтдаа ажиллаж үр өгөөж өгдөг нэг объект тул нийтэд нь “гэрэлтүүлэг” гэж нэг хөрөнгөөр, ашиглалтад авсан акт, гүйцэтгэлийн төсвийн задаргааг хавсаргаж бүртгэх нь оновчтой юм. Иймд орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд эд ангиар нь салгаж бүртгэсэн гэрэлтүүлгийн хөрөнгийг сум, байгууллага тус бүрээр тулгаж, нэгтгэн бүртгэлийг шинэчлэх ажлыг Орон нутгийн өмчийн газар хариуцан зохион байгуулах шаардлагатай байна.

3.3 Зөрилт 3. Элэгдэл тооцох, ашиглалтын хугацаа тогтоох, данснаас хасах үйл явцад хяналт хангалтгүй байна

Илэрсэн асуудал: 3.1	ТЕЗ-ийн харьяа 48 байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээ бүрэн нөхсөн 5,931.56 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэх, эсхүл данснаас хасах шийдвэр гаргуулаагүй зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө өндөр**
Бодит байдал:	ТЕЗ-ийн харьяа 48 байгууллага (ТШЗ-38, ААТҮГ-10)-ын дансанд элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөг “0” болсон 1,018 нэр төрлийн 5,931.56 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй (ТШЗ-д 701 нэр төрлийн 4,054.21 сая, ААТҮГ-т 317 нэр төрлийн 1,877.34 сая төгрөг) бөгөөд эдгээрийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, эсхүл акталж данснаас хасах шийдвэр гаргуулаагүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.”, 4.2.4-т 4.1.1-д заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” заавал мөрдөх, 5

	дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 67-д “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ...”, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 51-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үлдэх үнэ цэнийг санхүүгийн жил бүрийн эцэст дахин хянаж үзэх ...”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.26-д “Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцэх горимоор бүртгэнэ.”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь ... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн ... эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.”, Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/587 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн газрын дүрэм”-ийн 2.3-т “Орон нутгийн өмчийн байгууллагуудын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг ... акталж данснаас хасах тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэх саналыг байгууллага тус бүр тусад нь ирүүлдэг тул шийдвэр удаашрах; шийдвэр гаргах хугацаа, саналын загварыг тогтоогоогүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Ашиглагдаж буй хөрөнгийн бодит үнэ цэнэ санхүүгийн тайланд илэрхийлэгдэхгүй, ашиглалтаас гарсан хөрөнгө дансанд үлдэх, элэгдлийн хугацааг хэт богино тогтоосон алдаа илрэхгүй байх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** Байгууллага бүр үндсэн хөрөнгийн тооллогын дүнг үндэслэн элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах болон актлах хөрөнгөөр ангилж, холбогдох саналаа ОНӨГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх.

/Хавсралт 1-д байгууллага тус бүрээр харуулав/

Илэрсэн асуудал: 3.2	ТЕЗ-ийн харьяа 12 байгууллага 22.81 сая төгрөгийн элэгдлийг хөрөнгийн өртгөөс хэтрүүлж, мөн газар болон ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгөд элэгдэл тооцсон зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал:	**Нөлөө бага**
Бодит байдал:	12 ТШЗ-ийн үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоололд хяналт тавиагүйгээс нийт 22.81 сая төгрөгийн зөрчил гарсан бөгөөд

	үүнээс: • 8 байгууллага 17 нэр төрлийн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг анхны өртгөөс хэтрүүлэн тооцож, үлдэх өртгийг 18.12 сая төгрөгөөр сөрөг (хасах) дүнтэй тайлагнасан; • 4 байгууллага газар болон ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгөд 4.69 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.”, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 66-д “Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна.”, 74-т “... газар нь хязгааргүй ашиглалтын хугацаатай тул элэгдэл тооцдоггүй.”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.22-т “Элэгдүүлэх дүн нь хөрөнгийн өртөг, эсхүл өртгийг орлох бусад дүнгээс үлдэх өртгийг хассан дүн юм.”, 10.52-т “Үндсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бүртгэсний үр дүнд түүний өртгийг үндсэн хөрөнгийн данснаас хасах ба хуримтлагдсан элэгдэл ... дансны үлдэгдлийг хаана.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Программд элэгдэл автоматаар тооцогддог боловч анхны өртгөөр хязгаарлах, газар болон хугацаагүй хөрөнгийг элэгдлээс чөлөөлөх тохиргоо хийгдээгүй, нягтлан бодогч хянадаггүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Элэгдлийн зардал хэт өндөр тооцогдож, санхүүгийн үр дүн, хөрөнгийн үлдэх өртөг буруу тайлагнагдана.
Аудитын шийдвэрлэлт:	**Зөвлөмж:** 2026 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд буруу тооцсон элэгдлийг залруулах.

4. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ЗӨВЛӨМЖ

4.1 Зөрчлийг шийдвэрлэх гарц, байгууллага хоорондын уялдаа

Аудитаар илэрсэн зөрчлийн ихэнхийг тухайн байгууллага дангаараа залруулах боломжгүй байна. Газрыг үнэлэх, элэгдлээ нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэх, акталж хасах, капиталжуулах шийдвэрийг ОНӨГ, ТӨБЗГ гаргадаг бөгөөд газар, тээврийн хэрэгслийн эх мэдээлэл ГХБХБГ, АТҮТ, татварын албаны системд байна. Нэг хөрөнгө ТШЗ-ийн санхүүгийн программ, ТЕЗ-ийн нэгтгэл, ОНӨГ-ын өмчийн бүртгэл, Газрын нэгдсэн систем, АТҮТ болон татварын систем гэсэн таван бүртгэлд өөр өөр тоо, дүнтэй бүртгэгдэж, РД, кадастрын дугаар, арлын дугаар зэрэг нэгдсэн таниғчаар холбогддоггүй.

4.1.1 Хяналтын болон мэдээлэл эзэмшигч байгууллагуудын уялдаа

Хүснэгт 5. Хяналтын болон мэдээлэл эзэмшигч байгууллагуудын уялдаа

Байгууллага	Үүрэг, хяналтын хэрэгсэл	Хамаарах зөрчил	Уялдааны цоорхой
Төрийн аудитын байгууллага (Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар)	Санхүүгийн тайлангийн аудит, дүгнэлт; албан шаардлага, зөвлөмж, төлбөрийн акт	Бүгд	Дотоод аудитаар илэрсэн, залруулсан зөрчлийг аудитын дүгнэлт, албан шаардлагад хэрхэн тооцох нь тодорхойгүй; давхардсан шийдвэр гарах эрсдэлтэй
Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	Дотоод аудит, санхүүгийн хяналт; зөвлөмж, түүний хэрэгжилтийн хяналт	Бүгд	Зөвлөмжид шийдвэр шаардлагатай асуудлыг ОНӨГ, ТӨБЗГ-т заавал хүргүүлж, хариу авах журам байхгүй. Байгууллага аудитын явцад өөрөө засварласан алдааг “залруулсан” гэж бүртгэх шалгуур тогтоогоогүй.
Орон нутгийн өмчийн газар	Өмчийн нэгдсэн бүртгэл, үзлэг тооллого; акталж хасах, шилжүүлэх шийдвэр (А/587 дүрэм 2.3, 2.9, 2.10)	1.1, 1.3, 1.4, 2.1–2.3, 2.5, 2.6, 3.1	Хяналт, шийдвэр гаргах үүргийг зэрэг хэрэгжүүлдэг боловч шийдвэрийн хугацаагүй; бүртгэл нь ТЕЗ-ийн нэгтгэлээс 243.50 сая төгрөгөөр зөрүүтэй.
Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс	ТШЗ, ААТҮГ-ын тайланг хянаж нэгтгэх (Төсвийн тухай хуулийн 54.3); НББ-ийн бодлогын баримт бичиг	1.1, 1.2, 1.5	Тайлан хүлээн авахдаа санхүүгийн тайланг дэлгэрэнгүй бүртгэл, ОНӨГ-ын бүртгэлтэй тулгах шалгуургүй; бодлогын баримт бичгийг шинэчлээгүй (2021 оных)
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Газрыг үнэлж бүртгэх (271-р тогтоолын 3.8), ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэх (7.1)	1.3, 3.1	Саналыг байгууллага тус бүр тусад нь ирүүлдэг тул шийдвэр удаашрах
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Газрын эрхийн бүртгэл, барилга байгууламжийг ашиглалтад авах	1.3, 2.2, 2.3	Газрын эрхийн мэдээллийг ХУР системээс авах боломжтой боловч ОНӨГ, ТШЗ, ААТҮГ үүнийг ашиглан хөрөнгийн бүртгэлээ тулгадаггүй; ашиглалтад авах актад хөрөнгийн задаргаа тусгагддаггүй
АТҮТ, Татварын хэлтэс	Тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, татвар	1.4	Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн мэдээллийг ХУР системээс авах боломжтой боловч ОНӨГ, ТШЗ, ААТҮГ үүнийг ашиглан хөрөнгийн бүртгэлээ тогтмол тулгадаггүй
Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумын мал зүйч	Мал тооллого, малын бүртгэл	Мал, биологийн хөрөнгө	Байгууллагын өмчийн малыг төрөл, нас хүйсээр бүртгэх, тайлант хугацааны эцэст тооллогоор тулгаж төл, хорогдлыг баримтжуулах нэгдсэн журам тогтоогоогүй
ТШЗ, ААТҮГ (шалгагдагч)	Бүртгэл засах, санал боловсруулах, тооллого хийх	Бүгд	Олон байгууллагаас өөр өөр чиглэл авдаг; шийдвэр хүлээж залруулгаа хойшлуулдаг

Байгууллага хоорондын уялдаанд дараах гурван үндсэн цоорхой байна. Үүнд:

1. **Мэдээллийн цоорхой.** Газар, тээврийн хэрэгслийн эх бүртгэл тусдаа системд байх ба РД, кадастрын болон арлын дугаараар холбогддоггүй, тулгалтыг жилд нэг удаа гараар хийдэг.

2. **Шийдвэрийн цоорхой.** Зөрчлийн дүнгийн дийлэнхийг залруулахад ОНӨГ, ТӨБЗГ-ын шийдвэр шаардлагатай боловч шийдвэр гаргах хугацаа, санал ирүүлэх загвар тогтоогоогүй.
3. **Хэрэгжилтийн хяналтын цоорхой.** Санхүү, төрийн сангийн хэлтэс тайлан хүлээн авахдаа дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгуур болгодоггүй, Төрийн аудитын байгууллага үүнийг харгалздаггүй.

4.1.2 Зөрчлийг залруулах нэгдсэн арга

Зөрчлийн ихэнх нь мөнгөн хохирол бус бүртгэл, ангиллын алдаа тул УСНББОУС 3 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт ба алдаа”-ны дагуу өмнөх оны алдааг буцаан залруулах зарчмаар залруулж, тодруулгад тусгах боломжтой. Залруулгыг 2026 оны жилийн эцсийн тооллогоор (НББ-ийн тухай хуулийн 12.2.1) хийж, 2026 оны санхүүгийн тайланд тусгах нь зүйтэй.

Хүснэгт 6. Зөрчил тус бүрийн залруулгын нэгдсэн арга

Зөрчил	Залруулах арга	Эрх зүйн үндэслэл	Шийдвэр шаардлагатай эсэх
1.1, 1.2	Дэлгэрэнгүй бүртгэлийг үндсэн эх сурвалж болгож, ТШЗ–ОНӨГ–ТЕЗ гурвалсан тулгалтын актаар эхний үлдэгдлийг засах	НББ-ийн тухай хуулийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 54.3, УСНББОУС 3	Үгүй; тулгалтын акт хангалттай
1.3, 3.2 (газар)	ГХБХБГ-аас байгууллага тус бүрийн эзэмшлийн газрын жагсаалт авч ТӨБЗГ-т нэг бүр санал хүргүүлэх; газарт тооцсон элэгдлийг буцаах	271-р тогтоолын 3.8, УСНББОУС 17-гийн 74	ТӨБЗГ-ын багц шийдвэр
1.4	АТҮТ, татвараас РД-ээр жагсаалт авч биет тооллогоор нарийвчлах; акталсан хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах	НББ-ийн тухай хуулийн 12.2.1, 14.4.2	Бүртгэлд авахад ОНӨГ-ын шийдвэр
2.2, 2.3	Ашиглалтад авах акт, гүйцэтгэгчийн төсвийн задаргаагаар аль хөрөнгөд нэмэхийг тогтоож, нэр төрлөөр салгаж дахин бүртгэх	А/3 журмын 10.21, 10.46; 271-р тогтоолын 4.1	Үгүй; дотоод баримтаар
2.1, 2.4, 2.5	Аймгийн нэгдсэн ангиллын жагсаалт (хөрөнгийн нэр → данс, хэмжих нэгж, ашиглах хугацаа) гаргаж, данс хооронд дахин ангилах	А/3 журмын 1.3, 8.3, 10.6; УСНББОУС 12, 17	Үгүй
2.6	Үзлэгээр бодит байдлыг тогтоож ашиглалтад оруулах, эсхүл хаах; 39216 дансыг жишиг дансанд шилжүүлэх	А/3 журмын 1.3, 10.45	Сумын Засаг дарга, ОНӨГ
2.7	Хөрөнгийг ЗДТГ-ын балансад шилжүүлэх	А/361 журмын 1.5, 2.8	Санд нөхөн төвлөрүүлэх асуудал хэвээр
3.1	Тооллогоор “ашиглаж буй / актлах” гэж ангилж, ОНӨГ-оор дамжуулан ТӨБЗГ-т нэг бүр санал хүргүүлэх; ашиглах хугацааг тооцооллын өөрчлөлтөөр ирээдүйд тусгах	271-р тогтоолын 7.1, А/587 дүрмийн 2.3, А/3 журмын 10.26	ТӨБЗГ / ОНӨГ-ын багц шийдвэр
3.2 (сөрөг)	Элэгдлийг анхны өртөг хүртэл буцааж, программд хязгаарлалт тохируулах	А/3 журмын 10.22	Үгүй
1.5	Бодлогын баримт бичгийг шинэчилж, нэгдсэн зааврыг хавсралт болгох; мал, биологийн хөрөнгийн бүртгэлийг тусгах	НББ-ийн тухай хуулийн 18.2	Аймгийн Засаг даргын захирамж

Эх сурвалж: Аудиторын дүн шинжилгээ

Аймгийн хэмжээнд нэг ойлголтоор ажиллахын тулд дараах алхмыг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

1. **Нэгдсэн заавар батлуулах.** Хүснэгт 6-г “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн алдааг залруулах нэгдсэн заавар” болгон НББ-ийн бодлогын баримт бичгийн шинэчлэлтэй хамт Аймгийн Засаг даргын захирамжаар батлуулах (хариуцах: СХДАГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, ОНӨГ).
2. **Ажлын хэсэг байгуулах.** Дөрвөн хяналтын байгууллага болон ГХБХБГ, АТҮТ, Татварын хэлтэс, ХХААГ-ын төлөөлөлтэй ажлын хэсэг сар бүр хуралдаж, байгууллага тус бүрийн залруулгын жагсаалтыг хянах.
3. **Улсын системийн мэдээллийг нэгдсэн байдлаар авах.** Газар, тээврийн хэрэгслийн жагсаалтыг РД-ээр аймгийн хэмжээнд нэг хүсэлтээр авч ТШЗ-д тараах, жил бүр давтах тохиролцоог санамж бичгээр баталгаажуулах.
4. **2026 оны жилийн эцсийн тооллогоор залруулах.** Тооллогын удирдамжид улсын системтэй тулгах, ангиллыг засах алхмыг хийж, тооллогын актаар залруулгын бичилт хийх.
5. **Багц саналаар шийдвэрлүүлэх.** Газар үнэлэх, элэгдлээ нөхсөн хөрөнгийн саналыг ОНӨГ аймгаар нэгтгэж ТӨБЗГ-т хүргүүлэх, шийдвэрийг ТШЗ-д албан ёсоор хүргэх.
6. **“Залруулсан алдаа” гэж хүлээн зөвшөөрөх шалгуур тогтоох.** Тайлан хүлээлгэн өгөхөөс өмнө баримттай залруулсан алдааг зөвхөн бүртгэлд тэмдэглэх шалгуурыг дөрвөн хяналтын байгууллага хамтран баталж, илэрсэн зөрчил, залруулгын нэгдсэн бүртгэл хөтлөх.

Хязгаарлалт: *мөнгөн хохирол, зориулалтын бус зарцуулалт (2.7), бүртгэлгүй алдагдсан хөрөнгө илэрвэл залруулгаар хаахгүй бөгөөд төлбөрийн акт, хариуцлага тооцуулах журмын дагуу шийдвэрлэнэ.*

4.2 Мал, биологийн хөрөнгийн бүртгэл

Аудитын явцад ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын (сумын ЗДТГ, ААТҮГ) өмчийн мал, биологийн хөрөнгийг жилийн эцсийн мал тооллого, сумын малын бүртгэлтэй тулгасан мэдээлэл байхгүй, энэ ангиллын бүртгэл хөтлөх нэгдсэн журам тогтоогоогүй байна. Цаашид мал, биологийн хөрөнгийг дараах байдлаар бүртгэж, хянаж байхыг зөвлөж байна.

Бүртгэх нь

1. **Зөв ангилах.** Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглаж буй амьд малыг УСНББОУС 27 “Хөдөө аж ахуй”-н дагуу биологийн хөрөнгөөр бүртгэнэ. Малын хашаа, ванн, худаг зэрэг байгууламжийг барилга, байгууламжийн дансанд үндсэн хөрөнгөөр, тэжээл, мал эмнэлгийн эм, бэлдмэлийг бараа материалаар бүртгэнэ.
2. **Бодит үнэ цэнээр хэмжих.** Биологийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө болон тайлант хугацаа бүрийн эцэст бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээр хэмжинэ. Үнэ цэний өөрчлөлтийг тухайн хугацааны үр дүнд тусгах бөгөөд малд элэгдэл тооцохгүй. Малын төрөл, нас хүйсээр жишиг үнэ тогтоох аргачлалыг НББ-ийн бодлогын баримт бичигт тусгана.
3. **Дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх.** Малыг төрөл, нас хүйс, ялгах тэмдгийн (ээмэг, ид тэмдэг) дугаараар дэлгэрэнгүй бүртгэлд хөтөлнө. Төл бойжилт, хорогдол, зарлагыг хорогдлын акт, мал эмнэлгийн дүгнэлт зэрэг анхан шатны баримтаар бүртгэнэ.
4. **Маллуулж буй малыг хариуцуулах.** Бусдад маллуулж буй малыг гэрээ, хариуцагчаар нь бүртгэж, жил бүр тооцоо нийлсэн акт үйлдэнэ.

Тайлант хугацааны эцэст хянах нь

5. **Тооллого хийх.** Жил бүрийн 12 дугаар сард байгууллагын даргын тушаалаар томилсон комисс малыг төрөл, нас хүйсээр нь биеэр тоолж, ялгах тэмдгийн дугаарыг

тулган тооллогын хуудсанд бүртгэнэ. Маллуулж буй малыг маллагчийн байршилд очиж тоолно.

6. **Бүртгэлтэй тулгах.** Тооллогын дүнг дэлгэрэнгүй бүртгэлтэй төрөл, нас хүйс тус бүрээр дараах томьёогоор тулгана: эхний үлдэгдэл + бойжсон төл + худалдан авсан, шилжиж ирсэн − хорогдсон − зарлагадсан, шилжүүлсэн = эцсийн үлдэгдэл. Зөрүүг тооллогын актад тусгаж:
   - хорогдлыг мал эмнэлгийн дүгнэлт, хорогдлын актаар нотолж данснаас хасна;
   - баримтгүй дутагдлыг хариуцагчаас нөхөн төлүүлнэ;
   - илүүдлийг орлогод авна.
7. **Гадаад эх сурвалжтай тулгах.** Сумын мал зүйчийн жилийн эцсийн мал тооллогын дүнг байгууллагын тооллогын дүнтэй тулгаж, зөрүүг тодруулна.
8. **Үнэлж тайлагнах.** Тооллогоор баталгаажсан малыг тайлант хугацааны эцсийн бодит үнэ цэнээр дахин үнэлнэ. Малын тоо, дүнг ОНӨГ-ын өмчийн бүртгэлтэй тулгаж, санхүүгийн тайлангийн тодруулгад төрлөөр нь харуулна.

4.3 Зөвлөмж (хариуцах эзнээр)

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн илэрсэн бүх зөрчлийг арилгуулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан хариуцах эзэн, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагчид:

1. ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланг ОНӨГ-ын нэгдсэн бүртгэл, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлантай байгууллага тус бүрээр тулгаж баталгаажуулдаг хяналтын журам тогтоож, 2025 оны зөрүүг (нийт 758.81 сая төгрөг) залруулах ажлыг зохион байгуулах; /1.1/
2. Аймгийн Засаг даргын 2021 оны 58 дугаар захирамжаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалд нийцүүлэн шинэчилж, үндсэн хөрөнгийн анги тус бүрийн ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг нэгдсэн байдлаар тогтоох; /1.5/
3. Удаан хугацаанд (3–15 жил) дуусаагүй байгаа барилга, байгууламжийн бодит байдлыг үнэлүүлж, дуусгах, ашиглалтад оруулах, эсхүл бүртгэлээс хасах талаар шийдвэр гаргах; /2.6/
4. Эзэмшлийн газар, тээврийн хэрэгслийн бүртгэлийг улсын бүртгэлийн мэдээлэлтэй жил бүр тулгаж, баталгаажуулах үүргийг ТШЗ, ААТҮГ-ын удирдлагад хүлээлгэх; /1.3, 1.4/
5. “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн алдааг залруулах нэгдсэн заавар”-ыг (Хүснэгт 6) НББ-ийн бодлогын баримт бичгийн шинэчлэлтэй хамт батлуулж, байгууллага өөрөө баримттай залруулсан алдааг “Залруулсан алдаа” гэж бүртгэх шалгуурыг хяналтын байгууллагуудтай хамтран тогтоох; /Хүснэгт 6/
6. Хяналтын дөрвөн байгууллага болон ГХБХБГ, АТҮТ, Татварын хэлтэс, ХХААГ-ын төлөөлөлтэй ажлын хэсэг байгуулж, газар, тээврийн хэрэгслийн жагсаалтыг РД-ээр жил бүр солилцох санамж бичиг байгуулах. /1.3, 1.4/

Орон нутгийн өмчийн газарт:

1. Харьяа байгууллагуудын хөрөнгийн мэдээллийг ТЕЗ-ийн нэгтгэлтэй байгууллага тус бүрээр тулгаж, 2025 онд ОНӨГ-ын бүртгэлд илүү бүртгэгдсэн 243.50 сая төгрөг, 2024 оны 17,756.62 сая төгрөгийн зөрүүний шалтгааныг тодорхойлж залруулах; /1.1/
2. Газрын нэгдсэн бүртгэлийн систем, АТҮТ-ийн мэдээлэлтэй тулгаж, бүртгэлгүй 197 газар, 19 тээврийн хэрэгслийг өмчийн нэгдсэн бүртгэлд тусгуулах, бүртгэлтэй боловч улсын бүртгэлгүй хөрөнгийн эрх зүйн байдлыг шийдвэрлэх; /1.3, 1.4/
3. Элэгдлээ бүрэн нөхсөн 1,018 нэр төрлийн 5,931.56 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, эсхүл акталж данснаас хасах саналыг байгууллагуудаас авч шийдвэрлүүлэх; /3.1/
4. Өмчийн нэгдсэн бүртгэлийн “Дуусаагүй барилга, байгууламж” ангилалд бүртгэлтэй 23 нэр төрлийн 2,854.80 сая төгрөгийн хөрөнгийг ТШЗ-ийн бүртгэлтэй тулгаж, давхардал, бодит байдлыг тогтоох; /2.6/
5. Хөрөнгийн нэр, кодчилол, хэмжих нэгжийг нэгдсэн стандартаар хөтлөх заавар гаргаж, байгууллагуудын нягтлан бодогч, эд хариуцагч нарт сургалт зохион байгуулах; /2.1–2.5/
6. Газар үнэлэх, элэгдлээ нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэх саналыг аймгаар нэгтгэж ТӨБЗГ-т нэг багц саналаар хүргүүлэх, гарсан шийдвэрийг ТШЗ, ААТҮГ-т албан ёсоор хүргэх; /1.3, 3.1/
